



**ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 01 өдөр

Дугаар Б/18

Чингис хот

Ц.Ганчимэгт албан үүргийг түр орлон  
гүйцэтгэсний цалин, урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8, 43.3.3, Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолын 2.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн Агентлагийн хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа Нутгийн захиргааны байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Ганчимэгт тухайн албан тушаалд мэргэжилтэн томилогдох хүртэл албан тушаалын цалингийн 20 хувийн цалин, урамшуулал олгосугай.

2. Урамшууллыг 2019 оны 01 дүгээр сараас эхэлж тооцон олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР